

**“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2026.04.29

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны үйл
ажиллагааны болон санхүүгийн
тайланд өгсөн ТУЗ-ийн
дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн тооллогын комиссын 01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 80.05 %-ийн саналаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТБИЛЭГ

**“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2026.04.29

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн
Төлөөлөн удирдах
зөвлөлийн
гишүүдийг сонгох,
Төлөөлөн удирдах
зөвлөлийн төсвийг
батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь хэсэг, 62.1.13 болон 2026 оны 04 дүгээр сарын 29 - ний өдрийн тооллогын комиссын 01/02, 01/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Ц.Төмөр
2. Б.Баттөр
3. Ч.Цэцэгмаа
4. Т.Билэгт
5. Б.Батбилэг
6. Б.Батхишиг

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Э.Билгүүн
2. Б.Жаргал
3. С.Бат-Эрдэнэ

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг Төлөөлөн

удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

4. "Гутал" ХК-ийн 2026 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг 1 дүгээр хавсралтын дагуу 80.05 хувийн саналтай баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТБИЛЭГ

“Гутал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04-р сарын 29-ний өдрийн хурлын 02 тоот тогтоолын

Хавсралт №1



“Гутал” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв

№	Зардал	Сарын цалин төгрөг	Тоо	Бүгд төгрөг
1	ТУЗ-ийн дарга	5 000 000	1	60 000 000
2	ТУЗ-ийн гишүүн	1 000 000	8	96 000 000
3	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	800 000	1	9 600 000
4	ТУЗ-ийн бичиг хэрэг	жилд		2 700 000
5	Нийт дүн			168 300 000

**“ГУТАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026.04.29

Дугаар 03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилалтын тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл болон 2026 оны 04 дүгээр сарын 29 - ний өдрийн тооллогын комиссын 01 дугаар тогтоолыг тус тус үндэслэн

ТОГТООХ нь:

1. “Гутал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн 01 тоот тогтоолоор 2025 оны үйл ажиллагааны ашгаас нэгж хувьцаанд 3230 /гурван мянга хоёр зуун гучин/ төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хуралд танилцуулсаныг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТБИЛЭГ